

ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

"МАНДАХ 2025" ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ 6 ДАХЬ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах их сургуулиас 2 жил тутам зохион байгуулдаг олон улсын 6 дахь удаагийн Эрдэм шинжилгээний хуралд Тайланд, БНСУ, Казакстан, Англи, Австрали, Энэтхэг, Монгол улсын эрдэмтэн судлаачид оролцсон.

“Салбар хоорондын судалгаа ба тогтвортой хөгжил” сэдвийн дор зохион байгуулж буй “Мандах - 2025” олон улсын Эрдэм шинжилгээний хурал Эдийн засаг, бизнес болон Инженер, хүмүүнлэг, боловсрол гэсэн салбар хуралдаанаар явагдаж өнгөрлөө.

“Мандах - 2025” хурал нь их дээд сургуулийн эрдэмтэн судлаач, аж ахуйн нэгжүүд болон судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, салбар хоорондын харилцааг гүнзгийрүүлэн, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны түншлэлийг дэмжихэд чухал ач холбогдолтой болно гэдэгт итгэлтэй байна.




Үйл явдлууд

АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛИЙН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН ӨВЛИЙН УЛИРЛЫН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн Ахисан Түвшний сургуулийн 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн танхимын сургалтын нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 01 сарын 11-ны өдөр, онлайн сургалтын нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 01 сарын 16-ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдлаа. Нээлтийн үйл ажиллагаанд Ахисан Түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа нь “Ахисан Түвшний сургуулийн танилцуулга”-ыг нийт магистрантууддаа танилцуулж, 2024-2025 оны хичээлийн жилийн хугацаанд хийгдэх ажлуудыг онцлов. Ахисан түвшний сургуулийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан Ө.Мөнхзаяа нь нийт магистрантууддаа зориулан “Цахим сургалтын систем болон сургалтын үйл ажиллагаанд ашиглах системүүдийн танилцуулга”-ыг танилцууллаа.

Нээлтийн үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн нийт магистрантуудад зориулан Ахисан Түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа нь “Хувь хүний хөгжил ба орчин цагт шаардагдаж буй ур чадварууд” сэдвээр сургалт орлоо.



БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн Ахисан түвшний сургуулийн докторант Цэмбэл овогтой Номин нь 2024 оны 12 сарын 25-ны өдөр Монгол улсын их сургуулийн Бизнесийн удирдлагын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр “Хувь хүнд чиглэсэн онлайн зар сурталчилгааны үр нөлөөг тодорхойлох судалгаа” сэдвээр Бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D)-ын зэргээ амжилттай хамгаалж 2025.02.26-ний өдөр докторын диплом, энгэрийн тэмдгээ гардан авлаа. Ц.Номин докторынхоо цаашдын эрдэм судлалын ажилд өндрөөс өндөр амжилт хүсье.



ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛЛАА

Мандах Их сургуулийн Стратеги хөгжлийн бодлого эрхэлсэн проректор Сандагсүрэн овогтой Энхтуяа нь 2025 оны 02 сарын 11 -ны өдөр МУЭИС -ийн Боловсрол судлалын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр “Дээд боловсролын экспортыг судалсан нь” сэдвээр Боловсрол судлалын доктор (Ph.D) -ын зэрэг хамгааллаа. С.Энхтуяа доктордоо цаашдын эрдэм судлалын ажилд нь өндрөөс өндөр амжилтыг хүсье.



БМИҮЗ-ийн шинжээчид манай сургууль дээр АЖИЛЛАЖ БАЙНА

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Инженерчлэл, эдийн засаг” магистрын хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэлийг хийж, хөндлөнгөөс үнэлэх БМИҮЗ-ийн шинжээчид манай сургууль дээр ажиллаж байна.



ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛЛАА

Мандах Их Сургуулийн Эдийн засаг, бизнесийн тэнхимийн ахлах багш Л.Дансранбавуу 2025 оны 02 сарын 25-ны өдөр “Төслийн шийдвэр боловсруулахад макро эдийн засгийн зарим үзүүлэлтийг ашиглах нь” сэдвээр Менежментийн Ухааны доктор (Ph.D) -ын зэрэг



ДОНОРЫН ӨДӨРЛӨГ БОЛЛОО

Мандах Их Сургуулийн хамт олон жил бүр "Цусаа бэлэглэж цохилох зүрх бүхнийг аваръя" уриан дор Донорын өдөрлөгийг зохион байгуулдаг. Энэ жилийн өдөрлөгийг 2025 оны 3 сарын 12-ны өдөр цусны төвтэй хамтран зохион байгууллаа. Өдөрлөгт 74 багш, ажилтан, оюутнууд оролцож цусаа бэлэглэж эрдэнэт хүний амь нас аврах буянт үйлс бүтээж, 25 литр цус хандивлалаа. Нэг хүний бэлэглэсэн цус бүрийг гурав хуваан цус цусан бүтээгдэхүүн болгосноор 222 хүнд амьдрал бэлэглэх боломж бүрдсэн байна. Цусаа хандивласан хүмүүсийн 50% нь 3-11 дэх удаагаа цусаа хандивлаж 10-33 хүний амь аварсан сайхан мэдээтэй байна. Цусны төвөөс 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажиллав. Донор бүрд улаан лоолийн шүүс, хар шоколад, луувангийн шүүс бэлэглэв.



“ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, АСУУДАЛ ШИЙДЭЛ” СЭДЭВТ УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургууль, “Монголын тээвэр логистикийн түншлэл мэргэжлийн холбоо” - той хамтран санаачилж Зам, тээврийн яам болон Нийслэлийн авто тээврийн газрын дэмжлэгтэйгээр хэлэлцүүлэг амжилттай зохион байгууллаа.

Монгол улсын тээвэр, логистикийн салбарын тулгамдаж буй асуудлын талаар нээлттэй хэлэлцүүлэг хийж, шийдлийг тодорхойлоход хувь нэмэр оруулах, салбарын боловсон хүчнийг бэлтгэх оролцогч талуудын оролцоог хангаж ажиллах зорилготой энэхүү уулзалтанд төр хувийн хэвшил, мэргэжлийн холбооны төлөөлөл 96 байгууллагын 120 гаруй хүмүүс оролцлоо.

Тус хэлэлцүүлэгт тээвэр, логистикийн салбар болон боловсролын салбарын 7 илтгэл хэлэлцүүлэгдлээ. Үүнд Мандах ИС-ийг төлөөлөн Мандах Их Сургуулийн сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах Багш, доктор Д.Буяндэлгэр нар илтгэл хэлэлцүүлэн, панелистаар оролцлоо.



"НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН ХХVI ОЛИМПИАД" АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ММНБИ-ийн Хүндэт гишүүн, Сангийн 18 дахь сайд, Онц бөгөөд бүрэн эрхт элчин, Сүхбаатарын одонт Далрайн ДАВААСАМБУУГИЙН нэрэмжит "Нягтлан Бодох Бүртгэлийн Улсын ХХVI олимпиад" 2025 оны 4-р сарын 16-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Багийн дүнгээр:

- ☐СЭЗИС 1-р байр
- ☐Мандах ИС - Дархан салбар 2-р байр
- ☐Мандах ИС - Төв сургууль 3-р байр

Баг хамт олноороо амжилттай оролцож дэд болон гуравдугаар байранд шалгарсан нийт Манлайлагч Мандахчууддаа халуун баяр хүргэе!



“МАНДАХ МАЗААЛАЙ” САГСАН БӨМБӨГИЙН ЭРЭГТЭЙ ШИГШЭЭ БАГ МОНГОЛЫН ОЮУТНЫ ЛИГИЙН 2024-2025 ОНЫ “DIVISION 1”-ИЙН ШИЛДЭГ 8 БАГИЙН НЭГЭЭР ТОДОРЛОО

Мандах их сургуулийн Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн багш А.Даваадорж дасгалжуулагчтай Н. Амардалай ахлагчтай Сагсан бөмбөгийн “Мандах Мазаалай” эрэгтэй шигшээ баг Монголын оюутны лигт 2024-2025 оны “Division 1”-д шилдэг 8 багийн нэгээр шалгарсан бахдам сайхан амжилт гаргалаа. Өнгөрсөн жилийн амжилтаа ахиулсан, нийт тамирчдадаа баяр хүргэж, сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛТНУУДЫН ДУНД СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Манлайлагч мандахчуудын 5 төрөлт тэмцээн хоёр өдрийн турш 81 багц медаль, шилжин явах цомын төлөөх тэмцээн аваргуудаа тодрууллаа. Багш ажилтнуудын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг нээж Мандах Их Сургуулийн ректор МУ-ын Гавьяат Багш Профессор Г.Нанжид үг хэллээ. Энэ удаагийн тэмцээнд нийт багш ажилтнуудыг эрэмбэлж, ижил тэнцүү багт хувиарлагдсанаар тэмцээн онцлогтой зохион байгуулагдлаа.

Багийн дүнгээр: Н.Довчиндорж ахлагчтай REDRUM /улаан баг/ “Тэргүүн байр” шилжин явах цомын эзэн боллоо.

П.Батбаяр ахлагчтай Ялж ялгар /цэнхэр баг/ “Дэд байр”

М.Жанузах ахлагчтай Инфинити /ягаан баг/ “Гутгаар байр”



“JOB FAIR-2025” НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургууль ажил олгогчдын хүний нөөцийг бүрдүүлэхэд туслах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутнуудыг танилцах болон мэргэжлийн дадлага хийлгэхэд зуучлах, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой уламжлалт “JOB FAIR-2025” ажлын байрны нээлттэй өдөрлөгийг 2025.04.07-нд зохион байгууллаа. Энэ удаагийн арга хэмжээ өмнөх жилээс өргөн цар хүрээнд зохион байгуулагдаж Банкны салбар-6, Групп компани-8, Тээвэр логистик-3, Уул уурхай-4, Банк бус санхүүгийн байгууллага-6, Төрийн байгууллага-3, Аялал зуучлал-3, Даатгал-2, Аудит-4, Мэдээлэл технологи-5, Үйлдвэрлэл, барилга, хөрөнгө оруулалт-5, Бусад-6 гэх мэт 55 аж ахуй нэгж байгууллага оролцлоо.

Мандах Их Сургуулийн ректор профессор Г.Нанжид “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийн арга хэмжээг нээж үг хэллээ. Нээлтэнд Сургалт эрхэлсэн проректор доктор, профессор Ч.Төрбадрах, Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал дэд, профессор Х.Нямбаяр нар оролцлоо.



БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН 30 ДАХЬ УДААГИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн энэ удаагийн төгсөлтөөр 15 хөтөлбөрийн 367 төгсөгч диплом энгэрийн тэмдгээ гардан авлаа. Ёслолын арга хэмжээ Соёлын Төв Өргөөнд 2025.05.26 өдөр зохион байгуулагдлаа.

Бакалаврын өдрийн хөтөлбөрөөр амжилттай суралцаж 3,5 ба түүнээс дээш голч дүнтэй төгсөж буй 31 төгсөгч Ахисан түвшний сургуулийн магистрын хөтөлбөрт шалгалтгүй элсэн, хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийн 40%-ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг олголоо.



БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ БОЛОН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн бакалаврын эчнээ болон магистрын хөтөлбөрийн төгсөлтийн үйл ажиллагаа 2025 оны 06 сарын 26-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг нээж Мандах их сургуулийн ректор, гавьяат багш, профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд болон тухайн хөтөлбөрт хичээл заасан багш нарт баяр хүргэн, цаашдын ажил, хөдөлмөрт нь амжилт хүслээ. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө.



БҮРТГЭЛ ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭНХИМЭЭС ЖИЛ БҮР УЛАМЖЛАЛ БОЛГОН ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ 7 ХОНОГИЙН АЯН

БШТ-ээс жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг тогтвортой хөгжлийн боловсрол олгох 7 хоногийн аян 2025.05.12-2025.05.16-ны өдрүүдэд болж өнгөрлөө.

Аяны хүрээнд: 2025.05.12-21-ны өдрүүдэд Хариуцлагатай хэрэглээг дэмжих тогтвортой хөгжлийн хүрээнд “ХОЛИО, СОЛИО” өдөрлөгийг нийт багш, ажилтан, оюутнуудын хүрээнд өөрт байгаа ашиглахгүй шинэ болон гамтай хэрэглэсэн хуучин зүйлсээ бусадтай солилцох, зарж борлуулах байдлаар зохион байгуулсан.

2025.05.14-нд Чанартай боловсролыг дэмжих зорилтын хүрээнд оюутнуудыг идэвхижүүлж урамшуулах, хичээлдээ хандах хандлага, сонирхлыг нэмэгдүүлэх зорилготой “БАГШАА НАМАЙГ БОДООРОЙ” уралдаант тэмцээнүүдийг БШТ-ээс орж буй хичээлүүдийн хүрээнд зохион байгуулсан.

2025.05.15-нд Тогтвортой хөгжлийн зорилтуудыг таниулах, НББ-ийн хөтөлбөрөө сурталчилах зорилготой Brainy teens тэмцээнийг Мандах Лицей ахлах сургуулийн сурагчдын дунд Base Island, Brainy Bay Island, Green Mind Island, Balance Island гэсэн 4 өртөө байдлаар сонирхолтой тэмцээн танилцуулгуудыг агуулан зохион байгуулсан ба 11В, 11А ангиудын 20 суралцагч оролсон.

2025.05.16-НЫ 11:00 ЦАГТ

“БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ” ВЭБИНАР

БҮХ НИЙТИЙН ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛД ЗОРИУЛАВ

		
Х.НЯМБАЯР МАНДАХ ИХ СУРГУУЛЬ НББ-ИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ	Б.АМАРЖАРГАЛ САНГИЙН ЯАМ, НББ-ИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН	Л.БАДАМХАНД ММНБ-ИЙН СТОУС, АРГА ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
		
Д.УУГАНЗАЯА ТЕСО ГРУППИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН МЕНЕЖЕР	Б.СЭРЧМАА МАНДАХ ИХ СУРГУУЛЬ НББ-Н СУРГУУЛИЙН ОЮУТАН	Г.ЭНХ-ОТГОН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ НББ-Н СУРГУУЛИЙН БАГШ

Department of Accounting and Analysis

SUSTAINABLE DEVELOPMENT WEEK

2025.05.12
ХОЛИО, СОЛИО
Та бүхэн өөрт байгаа зүйлсээ бусадтай солилцох болон зарж борлуулах боломжтой

2025.05.13
ОЛИМПИАД
Оюутнуудын дунд Өртгийн бүртгэл, СДШНББ хичээлүүдийн олимпиад зохион байгуулах

2025.05.14
БАГШАА НАМАЙГ БОДООРОЙ
Сонирхолтой даалгавруудыг гүйцэтгэн оноо нэмүүлэх боломж

2025.05.15
BRAINY KID
Мандах лицей ахлах сургуулийн сурагчдад зориулсан үйл ажиллагаа

2025.05.16
ВЭБИНАР
Тогтвортой хөгжилтэй холбоотой вебинар зохион байгуулах

7 хоногийн турш багш, ажилтан, оюутнууд дууссан зай болон хандивын хувцас цуглуулж өрсөлдөх

Гадаад хамтын ажиллагаа

ТАЙВАНЫ ВУФЭНГ ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Тайваны Вуфэнг Их Сургуулийн ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид 2021.01.06 Мандах Их Сургуульд айлчлан хамтран ажиллах санамж байгуулсан билээ. Тус санамж бичгийн хүрээнд хоёр сургуулийн хамтран ажиллах гэрээг байгуулахаар Мандах Их Сургуулийн ректор Г.Нанжид, ЭЗБТ-ийн зөвлөх профессор Ч.Даваасүрэн нар Вуфэнг Их Сургуулийн урилгаар тус сургуульд зочлов. Энэ үеэр Вуфэнг Их Сургуультай танилцаж 2025.01.10 нд хамтран ажиллах гэрээг байгуулав.

Гэрээг Мандах Их Сургуулийн талаас ректор Г.Нанжид Вуфэнг Их Сургуулийн талаас ерөнхийлөгч Хун Жун Цай нар үзэглэв. Энэхүү гэрээний хүрээнд хоёр сургууль багш, ажилтан, оюутан солилцоо, эрдэм шинжилгээ судалгаа мэдээлэл солилцоо, болон 2+2 хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллахаар боллоо.



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ БОЛОН КАЗАХ-БРИТИШ ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛИЙН ХООРОНД ОЮУТАН СОЛИЛЦООНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Мандах их сургууль болон Казах-Бритиш Техникийн их сургуулийн хооронд өмнө 2024 оны 4-р сарын 16-нд доорх чиглэлээр ажиллахаар санамж бичиг байгуулж байсан. Энэ удаад оюутан солилцооны гэрээнд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагаа Мандах их сургууль дээр боллоо.

Мандах их сургуульд болсон уг үйл ажиллагаанд Бүгд Найрамдах Казахстан Улсын Казах- Бритиш Техникийн их сургуулийн олон улсын газрын захирал Бекнур Стибаев тэргүүтэй төлөөлөл болон Мандах их сургуулийн сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 2 – р сарын 4 – ний өдөр байлцлаа.

Энэхүү оюутан солилцооны гэрээг байгуулснаар хоёр байгууллагын хамтын ажиллагаа өргөжиж, оюутнууд 1-2 улирлын хугацаанд Англи хэлээр хичээл судлах, цаашлаад багш солилцоо хийгдэх, эрдэм шинжилгээний судалгааны ажлаар туршлага солилцох мөн санамж бичигт заагдсан бусад ажлын хүрээнд хамтран ажиллах боломж бүрдэж



**МАНДАХ ИХ СУРГУУЛЬ БОЛОН БНСУ-ЫН
ПОЛИТЕХНИК IV КОЛЛЕЖИЙН ТЭЖОН ХОТ ДАХЬ
САЛБАР СУРГУУЛЬ ХООРОНД ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ
ЗУРЛАА**

Мандах их сургууль болон БНСУ-ын Политехникийн IV коллеж (Korea Polytechnics) - ийн Тэжон хот дахь салбар сургууль хооронд хамтын ажиллагааны санамж бичгийг Мандах их сургуулийн байранд 2025 оны 2-р сарын 17-ны өдөр байгууллаа.

Тус санамж бичгийн зорилго нь боловсрол сургалт, дадлага, судалгаа хөгжүүлэлт, технологи дамжуулалт, мэдлэг түгээх, энтрепренершип зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан ойлголцлыг дэмжихэд оршино.

Тус үйл ажиллагаанд Мандах их сургуулийн ректор Г.Нанжид, сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, стратеги болон хөгжлийн бодлого эрхэлсэн проректор С.Энхтуяа, ахлах багш Т.Ганхуяг, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан Б.Чинбат зэрэг төлөөлөгч мөн БНСУ-ын Политехникийн IV коллежийн цахилгаан хяналтын тэнхимийн захирал Донван Лий, хиймэл оюун ухааны тэнхимийн профессор Ким Хак Жүү, салбарын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ажилтан Сүүн Тайг Квон нар байлцлаа.



“МОНГОЛЫН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТҮНШЛЭЛ МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” ТББ-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Мандах их сургуулийн төв байранд 2025 оны 2 – р сарын 7 – ны өдөр “Монголын тээвэр логистикийн түншлэл мэргэжлийн холбоо” ТББ болон Мандах их сургуулийн хооронд хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Тус үйл ажиллагаанд “Монголын тээвэр логистикийн түншлэл мэргэжлийн холбоо” ТББ – г төлөөлж ерөнхийлөгч А.Мөнхболд, гүйцэтгэх захирал Э.Удвал, Мандах их сургуулийг төлөөлж ректор Г.Нанжид, сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, ахлах багш доктор Б.Сайнжаргал, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан Б.Чинбат тэргүүтэй төлөөлөл байлцлаа.

Талууд тус гэрээний хүрээнд тээвэр логистикийн чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах, судалгаа шинжилгээ явуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах.



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Говьсүмбэр аймагт нэн шаардлагатай байгаа ажилтан, албан хаагчдын хүний нөөцийг бэлтгэх, хомсдолыг бууруулах чиглэлээр Мандах Их Сургууль болон Говьсүмбэр аймгийн засаг даргын тамгын газар хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Уг гэрээний хүрээнд тус сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын эчнээ болон “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийг цахим болон танхим хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэх юм.

Мөн харилцан дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллах, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, олимпиад, хэлэлцүүлэг зохион байгуулах, оюутнуудад онолын мэдлэгээ практикт бататгах зорилготой дадлага хийх зэрэгт хамтарч ажиллах юм.

Хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл ажиллагаанд сургалтын эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, Ахисан түвшний сургуулийн захирал О.Бурмаа, НББ-ийн сургуулийн захирал Х.Нямбаяр, ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнээ, Говьсүмбэр аймгийн засаг дарга Т.Бат-Эрдэнэ, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга У.Занабазар нар оролцлоо.



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Мандах Их Сургууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ) – ын хооронд хамтран ажиллах гэрээг ШШГЕГ - ын байранд 2025 оны 5 – р сарын 5 – ны өдөр байгууллаа.

Тус гэрээний зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шаардагдах боловсон хүчнийг бэлтгэх, тэдний карьер өсөлтийг дэмжих, чадавхжуулахад чиглэсэн магистр, бакалавр болон зэргийн бус сургалтын хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэхэд оршино.



Шагнал урамшуулал

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ 2024-2025 ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ОНЫ ШИЛДЭГ ОЮУТАН, ШИЛДЭГ ХАМТ ОЛОН, ШАЛГАРУУЛЛАА

Мандах Их Сургуулийн Үүсгэн байгуулагдсан өдрийг тохилдуулан шилдэг оюутан, шилдэг хамт олон, шилдэг клубийг шалгаруулдаг уламжлалтай билээ. 2025.05.15-ны өдөр зохион байгуулж, сурлагаар тэргүүлэгч шилдэг оюутан, эрдэм шинжилгээ судалгааны ажлаар тэргүүлэгч оюутан, урлаг спортоор тэргүүлэгч шилдэг оюутнуудыг тус тус шагнав. Мөн тус өдөр сургуулиа төлөөлөн олон улсын уралдаан тэмцээн, олимпиадад амжилттай оролцсон оюутнуудыг шагнаж урамшууллаа.



ХҮМҮҮНЛЭГ, БОЛОВСРОЛ СУДЛАЛ СУДАЛГААНЫ БАГИЙН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ VIII БАГА ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах их сургуулийн Гадаад хэлний тэнхимийн Хүмүүнлэг Боловсрол Судлалын судалгааны багийн Оюутны эрдэм шинжилгээний бага хурал 2025.03.19-ний өдөр зохион байгуулагдаж бакалаврын өдрийн хөтөлбөрийн 1-4-р түвшиний нийт 33 оюутан багийн болон ганцаарчилсан хэлбэрээр амжилттай оролцож 14 илтгэл хэлэлцүүлээ.

Тус хуралд салбар болон бүрэлдэхүүн сургуулийн давхардсан тоогоор 18 багш оюутнуудаа удирдаж эрдэм шинжилгээ, судалгааны ажлын практик чадвар эзэмших, мэдээлэлтэй ажиллах, бүтээлч сэтгэлгээ, онол-практикийн мэдлэг, бие даан шийдвэр



БҮРТГЭЛ ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭНХИМЭЭС НББ ХӨТӨЛБӨРИЙН 3-Р ТҮВШНИЙ ОЮУТНУУДЫН ДУНД “ӨРТГИЙН БҮРТГЭЛ” ХИЧЭЭЛИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Бүртгэл шинжилгээний тэнхимээс нбб хөтөлбөрийн 3-р түвшний оюутнуудын дунд “өртгийн бүртгэл” хичээлийн олимпиад зохион байгууллаа. Олимпиадад төв сургуулийн өдрийн ангийн 3-р түвшний 20, Дархан салбарын 3-р түвшний 8 нийт 28 оюутан оролцсон юм. Тус олимпиадыг Монгол Такс ТМЗ компани 13 дахь жилдээ ивээн тэтгэж, шагналт байранд шалгарсан оюутнуудыг мөнгө болон эд бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.

Мөн НББ-ийн Аудит хөтөлбөрийн 3-р түвшний оюутнууд Монгол Такс ТМЗ компанид “Office tour” буюу танилцах аялал хийж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллгаатай танилцлаа.



**“АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН
СУРГУУЛИЙН НЭРЭМЖИТ” МАГИСТР БОЛОН ЭЧНЭЭ
ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАГЧДЫН ДУНДАХ СПОРТЫН 4 ТӨРӨЛТ
ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

Ахисан түвшний сургууль, нягтлан бодох бүртгэлийн сургуулийн нэрэмжит” магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын дундах спортын 4 төрөлт тэмцээн 2025 оны 03-р сарын 23-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Энэхүү тэмцээнд нийт 13 баг тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, дартс гэсэн 4 төрлөөр тамирчдын хурд хүч авхаалж самбааг сорин өрсөлдлөө. Тэмцээнийг нээж Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал дэд профессор Х.Нямбаяр нээж үг хэллээ.

Магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын тэмцээний нийлбэр дүнгээр 2024-2025 оны магистрын намрын элсэлтийн Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрийн хамт олон анги Тэргүүн байр эзэлж “Шилжин явах цомын эзэн”-ээр тодорлоо.



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АВХААЛЖ СОРИХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

НББ-ийн сургуулийн БШТ нь 1998 оноос эхлэн жил бүр НББ-ийн хөтөлбөрийн 3-р түвшний ангиудын дунд “НББ-ийн АСТ”-ийг зохион байгуулсаар ирсэн. 28 дахь удаагийн АСТ нь 04-р сарын 08, 10-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд НББ-ийн хөтөлбөрийн 6 ангийн нийт 4 баг оролцлоо. Багууд 1-р шатанд 4, 2-р шатанд 7 нийт 11 төрлийн тэмцээнээр өрсөлдөж, шилдгүүдээ шалгарууллаа.

